

“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020.05.27

Улаанбаатар хот

Хурал 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 16:00-16:40 цагийн хооронд Google ZOOM app- аар цахим хурлыг хийв.

Хуралд оролцсон:

1. Б.Наранзул - 57399
2. Б.Наранцацралт /итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Наранзул/ - 26655
3. “Минжит булган гол”ХХК /итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Наранзул/ - 14918
4. Т.Баярхүү /итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Наранзул / - 1034
5. Н.Эрдэмбилэг -53842
6. Н.Эрдэмбаяр /итгэмжлэгдсэн төлөөлөгч А.Номинзул/ - 23306

Хурлын дарга Б.Наранзул хувьцаа эзэмшигчдийн ирцийг танилцуулж саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийг танилцуулав. Үүнд:

“Хөнгөн бетон” ХК-ийн зарласан бөгөөд гаргасан энгийн хувьцааны 179373 ширхэг хувьцаа ба ирсэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаа 177154 ширхэг байгаа ба 99%-ийн ирцтэй байгаа тул хүчин төгөлдөр гэж үзэж хурлыг нээснийг мэдэгдэв.

Хурлын дэг, дарааллын дагуу ХЭ-ийн хурлаар 3 асуудал танилцуулж хэлэлцэнэ:

- 1) Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
 - 2) ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох, цалин урамшууллын талаар
 - 3) Ногдол ашиг хуваарилахгүй талаар танилцуулах,
- дараа нь эхний 2 асуудал дээр санал хэлэлцээд саналын хуудсаар санал хурааж шийдвэрлэнэ. Үүнд:
- Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах, -/саналын хуудсыг мэйлээр явуулсан/
 - ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох- /саналын хуудсыг мэйлээр явуулсан/ куммлятив аргаар

Шийдвэрлэсэн нь: Хурлын дараалал, дэгийг өөр санал гаргаагүй тул хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 %-ийн саналаар батлав.

Асуудал 1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.

Хурлын дарга Б.Наранзул: Компанийн 2019 оны үйл ажиллагааны талаар товч танилцуулав.

Хөнгөн Бетон ХК нь түрээс болон дэд бүтцээ ашиглуулах үйл ажиллагаа явуулж байна. Компанийн шинэ удирдлага нь дээрх хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас компанийг хэвийн авч явахад хүндрэлтэй байсан ба санхүүгийн тайлан балансыг гадны байгууллагаар хийлгэж ирсэн. Компани өөрийн гэсэн ажилчид байхгүй байна. Компани 2019 онд 302,75 сая төгрөгийн орлого олсон. Авлагатай хувь хүн компаниуд тэдгээрийн шүүхийн шийдвэрийн өр төлбөрт тодорхой төлөлтүүд хийгдэн 8 хавтаст хэрэг байснаас 3 хавтаст хэргийг хаасан. 2 төлбөрийг 2020 онд хувиарт оруулан төлж эхлээд байна. Банкны болон бусад өр төлбөрүүд одоогоор оны эцсийн байдлаар хэвээр үлдэгдэлтэй байна.

Гол түүхий эд нийлүүлэгч компанид олон жилийн өглөгийг хөрөнгө шилжүүлэхээр шүүхийн явцад эвлэрсэн. Одоогоор шилжүүлж чадаагүй байгаа бөгөөд газар нь банкны барьцаанд байгаа юм. Түрээсийн гэрээ нь их хэмжээний хэлцэлд тооцогдох ба жил бүр гэрээг дүгнэн явж байна. 2019 оноос компани бүхэлдээ зогсож зөвхөн түрээсийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Хурлын дарга: Б.Наранзул: Та нар үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах эсэх саналаа саналын хуудсаар бөглөөд мэйл шуудангаар буцаагаад явуулаарай.

Асуудал 2. Ногдол ашиг хуваарилахгүй талаар танилцуулах нь

Хурлын дарга Б.Наранзул:

“Хөнгөн бетон” ХК нь 2019 онд алдагдалтай, үйл ажиллагаа явуулаагүй ба банкны өмнө хүлээсэн зээлийн гэрээний үүргийн дагуу ногдол ашиг хуваарилах боломжгүй байгаа гэдгийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Хурлын дарга: Б.Наранзул: Энэ асуудал дээр санал хураахгүй.

Асуудал 3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

Хурлын дарга Б.Наранзул: Өмнөх ТУЗ бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорч, эрхгүй болсон тул энэ удаагийн ХЭ-ийн хурлаар шинэ ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлсэн саналыг танилцуулж байна.

а/ ТУЗ-ийн ердийн гишүүд:

1. Тошил овогтой Баярхүү
2. Баярхүү овогтой Наранзул
3. Баярхүү овогтой Наранцацралт
4. Баасанжав овогтой Мөнхцацралт
5. Нэмэхбаатар овогтой Эрдэмбилэг
6. Нэмэхбаатар овогтой Эрдэмбаяр

б/ ТУЗ-ийн хараат бус гишүүд:

7. Бямбасүрэн овогтой Батболд
8. Шаравсамбуу овогтой Энхтөр
9. Дашхүү овогтой Хасбаатар

Хурлын дарга Б.Наранзул: ТУЗ-ийн гишүүдийг куммулятив аргаар сонгоно, нэр дэвшсэн хүмүүст өгөх саналын тоогоо өгөөд саналаа хураая. /Саналын хуудсаа мэйлээр явуулсан./ Куммулятив аргын тухай саналын хуудасны доод хэсэгт тайлбар бичсэн байгаа, тэр тайлбарыг уншаад зааврын дагуу саналаа бөглөөрэй. (Ер нь бол өөрийнхөө хувьцааны тоог 9 сонгогдох гишүүний тоогоор үржүүлээд, санал өгөх гишүүнийхээ тоонд хуваана.)

Хурлын дарга Б.Наранзул: Тооллогын комисс саналын хуудсуудыг авч нэгдсэн дүнгээ гаргаад саналын тоог танилцуулаарай.

Тооллогын комиссын дарга Н.Бүрэнжаргал: Саналын хуудсыг нэгтгэн тооллоо. Үүнд:

- 1) Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг батлахад саналын хуудсаар санал хураахад хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн байна.

- 2) ТУЗ-ийн ердийн ба хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг куммулятив аргаар санал хураахад :

Ердийн гишүүд:

Д/д	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Куммулятив аргаар өгсөн саналын эрхийн тоо
1	Тошил овогтой Баярхүү	150008
2	Баярхүү овогтой Наранзул	150010
3	Баярхүү овогтой Наранцацралт	150010
4	Баасанжав овогтой Мөнхцацралт	150010
5	Нэмэхбаатар овогтой Эрдэмбилэг	231444
6	Нэмэхбаатар овогтой Эрдэмбаяр	231444

Хараат бус гишүүд:

д/д	ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Куммулятив аргаар өгсөн саналын эрхийн тоо
1	Бямбасүрэн овогтой Батболд	231444
2	Шаравсамбуу овогтой Энхтөр	150008
3	Дашхүү овогтой Хасбаатар	150008

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн дээрхи саналын эрхийн тоогоор тус тус санал авч, ТУЗ-ийн ердийн гишүүн ба хараат бус гишүүнээр сонгогдов.


Б.Наранзул: За ингээд хэлэлцэх асуудал дууссан тул хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хаасныг мэдэгдье.

Тэмдэглэл хөтөлсөн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



Б.Ундрах

Хурлын тэмдэглэлтэй танилцсан: Хувьцаа эзэмшигчид:

1.  Б.Наранзул
2. Н.Эрдэмбилэг
3.  Б.Наранцацралт /түүнийг төлөөлж Б.Наранзул/
4. Н.Эрдэмбаяр /түүнийг төлөөлж А.Номинзул/
5.  “Минижт булган гол” ХХК, /түүнийг төлөөлж Б.Наранзул/
6.  Т.Баярхүү, /түүнийг төлөөлж Б.Наранзул/

